

2020 оныг “Нэг хот-Нэг стандарт”
зорилтот жил болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, хотын стандарт, норм, дүрэм, журам, хэм хэмжээг мөрдүүлж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жил болгон зарласугай.

2.“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

3.“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсэг /Ж.Батбаясгалан/-т даалгасугай.

4.Зорилтот жилийн хүрээнд нийслэлээс зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллага, нэгж бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

5. Хотын стандарт, норм, дүрмийн талаарх мэдлэг ойлголтыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд түгээн хэвшүүлэх замаар тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, хотын стандартыг мөрдүүлэхэд бүх нийтийн оролцоог хангуулж ажиллахыг дүүрэг, хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, явц үр дүнг улирал тутамд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг /Ж.Батбаясгалан/-т, жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчлан ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	- Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан
Дэд дарга	- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд	- Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга
	- Дүүргүүдийн Засаг дарга нар
	- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн дарга нар
	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хэлтсийн дарга нар
	- Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга
	- Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга
	- Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга
	- Нийслэлийн Байгаль орчны газрын дарга
	- Нийслэлийн Боловсролын газрын дарга
	- Нийслэлийн Бүртгэлийн газрын дарга
	- Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга
	- Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
	- Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дарга
	- Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга
	- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
	- Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга
	- Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дарга
	- Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газрын дарга
	- Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга

- Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга
- Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга
- Нийслэлийн Статистикийн газрын дарга
- Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга
- Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга
- Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын дарга
- Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга
- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга

Нарийн бичгийн
дарга